



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/891

Ховд

Төсөл сонгон шалгаруулалтаар  
газар эзэмшүүлэх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалтанд оролцож ялагч болсон "Батдайчин" ХХК /4073886/-д Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэр Шинэ суурьшлын бүсэд байрлах, 0,6 га газрыг хаус хорооллын зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулан гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ